



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэт хотын захирагчийн албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022/04/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Эрдэнэт хот  
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах  
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ  
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Ахлах аудитор: В.Жавзмаа  
Утас: 70357955 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт .....	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал .....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



### ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 69

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЭРДЭНЭТ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН  
АЛБАНЫ ТӨСВИЙН ЗАХИРАГЧ  
С.ГАНЦОГТ ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэт хотын захирагчийн албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэт хотын захирагчийн албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>18,502,929.82</b>	<b>15,848,364.82</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	18,502,929.82	15,848,364.82
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	185,000.00	860,200.00
35110	Тусгай зориулалттай материал	185,000.00	860,200.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,097,670.00	4,097,670.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	14,220,259.82	10,890,494.82
35410	Бичиг хэргийн материал	1,435,305.00	842,600.00
35420	Аж ахуйн материал	11,839,505.00	9,158,695.00
35430	Сэлбэг хэрэгсэл	825,000.00	825,000.00
35440	Түлш, шатах тослох материал	60,449.82	4,199.82
35470	Бусад хангамжийн материал	60,000.00	60,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>21,961,887.45</b>	<b>55,812,296.15</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	21,961,887.45	55,812,296.15
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	21,511,887.45	46,678,962.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	49,000,000.00	49,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(49,000,000.00)	(49,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	82,964,183.00	117,393,913.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(69,597,327.69)	(77,532,610.29)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,835,507.75	18,550,707.75
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,690,475.61)	(11,733,047.62)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	450,000.00	9,133,333.31
39301	Програм хангамж	1,988,000.00	11,988,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,538,000.00)	(2,854,666.69)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>40,464,817.27</b>	<b>71,660,660.97</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>40,464,817.27</b>	<b>71,660,660.97</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	40,464,817.27	71,660,660.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	53,946,544.97	53,946,544.97
51101	Өмч: - төрийн	53,946,544.97	53,946,544.97
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(14,398,322.29)	16,797,521.41
51210	Өмнөх үеийн үр дүн	(14,398,322.29)	(14,398,322.29)
51220	Тайлант үеийн үр дүн	-	31,195,843.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	916,594.59	916,594.59
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>40,464,817.27</b>	<b>71,660,660.97</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>262,456,166.40</b>	<b>264,907,620.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>11,404,466.40</b>	<b>44,526,720.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Үндсэн хөрөнгө	11,240,666.40	44,391,720.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -Бараа материал	163,800.00	135,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>251,051,700.00</b>	<b>220,380,900.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	16,130,400.00	1,733,800.00

Эрдэнэт хотын захирагчийн албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,130,400.00	1,733,800.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	234,921,300.00	218,647,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	234,921,300.00	218,647,100.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>267,389,153.27</b>	<b>233,691,517.88</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>267,389,153.27</b>	<b>233,691,517.88</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	228,590,545.10	230,493,024.48
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	153,308,019.26	172,530,949.20
210101	Үндсэн цалин	105,165,483.39	122,892,370.20
210102	Нэмэгдэл	41,497,166.87	34,581,579.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,645,369.00	15,057,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	20,363,861.83	23,297,070.34
210201	Тэтгэврийн даатгал	14,032,857.30	16,224,380.70
210202	Тэтгэмжийн даатгал	1,648,294.60	1,818,573.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,255,616.05	1,401,099.00
210204	Ажилгүйдлийн даатгал	313,878.76	350,274.85
210205	Эрүүл мэндийн даатгал	3,113,215.12	3,502,741.94
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,830,367.39	12,569,954.56
210401	Бичиг хэрэг	4,925,735.00	6,668,917.00
210402	Тээвэр, шатахуун	4,929,751.65	4,691,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	974,880.74	1,209,787.56
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	880,200.00	1,580,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	880,200.00	1,580,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	19,458,600.00	1,263,800.00
210604	Урсгал засвар	19,458,600.00	1,263,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	770,000.00	4,942,800.00
210702	Дотоод албан томилолт	770,000.00	4,942,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,601,540.00	1,106,587.50
210803	Даатгалын үйлчилгээ	65,340.00	98,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,200.00	56,577.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	937,000.00	930,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	21,377,956.62	13,201,862.88
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,377,956.62	13,201,862.88
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	38,798,608.17	3,198,493.40
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,998,000.00	1,958,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,557,000.00	1,958,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	36,800,608.17	1,240,493.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,800,608.17	1,240,493.40
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(4,932,986.87)</b>	<b>31,216,102.12</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	109,650,000.00	20,258.42
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	109,650,000.00	20,258.42
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(109,650,000.00)	(20,258.42)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(114,582,986.87)</b>	<b>31,195,843.70</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	53,946,544.97	916,594.59	100,184,664.58	155,047,804.14
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>53,946,544.97</b>	<b>916,594.59</b>	<b>100,184,664.58</b>	155,047,804.14
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(114,582,986.87)	(114,582,986.87)
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>53,946,544.97</b>	<b>916,594.59</b>	<b>(14,398,322.29)</b>	40,464,817.27
<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>53,946,544.97</b>	<b>916,594.59</b>	<b>(14,398,322.29)</b>	40,464,817.27
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>53,946,544.97</b>	<b>916,594.59</b>	<b>(14,398,322.29)</b>	40,464,817.27
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	31,195,843.70	31,195,843.70
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>53,946,544.97</b>	<b>916,594.59</b>	<b>16,797,521.41</b>	71,660,660.97

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>251,051,700.00</b>	<b>227,590,732.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>251,051,700.00</b>	<b>227,590,732.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	16,130,400.00	1,733,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,130,400.00	1,733,800.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	234,921,300.00	218,647,100.00

Эрдэнэт хотын захирагчийн албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	234,921,300.00	218,647,100.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	-	7,209,832.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	7,209,832.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>251,051,700.00</u></b>	<b><u>227,590,732.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>251,051,700.00</b>	<b>227,590,732.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>212,253,091.83</b>	<b>217,182,406.60</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	153,308,019.26	172,530,949.20
210101	Үндсэн цалин	105,165,483.39	122,892,370.20
210102	Нэмэгдэл	41,497,166.87	34,581,579.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,645,369.00	15,057,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	20,363,861.83	23,297,070.34
210201	Тэтгэврийн даатгал	14,032,857.30	16,224,380.70
210202	Тэтгэмжийн даатгал	1,648,294.60	1,818,573.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,255,616.05	1,401,099.00
210204	Ажилгүйдлийн даатгал	313,878.76	350,274.85
210205	Эрүүл мэндийн даатгал	3,113,215.12	3,502,741.94
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,251,670.74	11,898,999.56
210401	Бичиг хэрэг	6,199,920.00	6,189,212.00
210402	Тээвэр, шатахуун	4,826,400.00	4,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,225,350.74	1,209,787.56
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	4,329,900.00	1,580,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,329,900.00	1,580,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,638,100.00	1,826,000.00
210604	Урсгал засвар	9,638,100.00	1,826,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	770,000.00	4,942,800.00
210702	Дотоод албан томилолт	770,000.00	4,942,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,591,540.00	1,106,587.50
210803	Даатгалын үйлчилгээ	65,340.00	98,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,200.00	56,577.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	937,000.00	930,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>38,798,608.17</b>	<b>10,408,325.40</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,998,000.00	9,167,832.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	7,209,832.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,998,000.00	1,958,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	36,800,608.17	1,240,493.40
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	36,800,608.17	1,240,493.40
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	218,647,100.00	217,406,606.60
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	218,647,100.00	217,406,606.60
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	216,647,100.00	215,448,606.60
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	172,572,200.00	172,530,949.20
210101	Үндсэн цалин	123,163,100.00	122,892,370.20
210102	Нэмэгдэл	42,453,900.00	34,581,579.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,955,200.00	15,057,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,297,200.00	23,297,070.34
210201	Тэтгэврийн даатгал	16,394,400.00	16,224,380.70
210202	Тэтгэмжийн даатгал	1,725,700.00	1,818,573.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,380,600.00	1,401,099.00
210204	Ажилгүйдлийн даатгал	345,100.00	350,274.85
210205	Эрүүл мэндийн даатгал	3,451,400.00	3,502,741.94
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,925,800.00	11,898,999.56
210401	Бичиг хэрэг	6,200,000.00	6,189,212.00
210402	Тээвэр, шатахуун	4,500,000.00	4,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,225,800.00	1,209,787.56
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,580,000.00	1,580,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,580,000.00	1,580,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,826,000.00	1,826,000.00
210604	Урсгал засвар	1,826,000.00	1,826,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,769,300.00	3,209,000.00
210702	Дотоод албан томилолт	3,769,300.00	3,209,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,676,600.00	1,106,587.50
210803	Даатгалын үйлчилгээ	117,700.00	98,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,200.00	56,577.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	937,700.00	930,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,000,000.00	1,958,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,000,000.00	1,958,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,958,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	218,647,100.00	218,647,100.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	218,647,100.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	218,647,100.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,733,800.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,733,800.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,733,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,733,800.00
210702	Дотоод албан томилолт	1,733,800.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,733,800.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,733,800.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,733,800.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэт хотын захирагчийн албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор В.Жавзмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэт хотын захирагчийн алба 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 14 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Эрдэнэт хотын захирагчийн алба нь Эрдэнэт хотын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, инженерийн бүх төрлийн шугам сүлжээний найдвартай, хэвийн ажиллагааг хангуулах болон орон сууц, хотын тохижилт, зам талбайн ашиглалт, реклам чимэглэл, инженерийн байгууламжийн үйл ажиллагааг зохицуулах, тэдгээрийг шинэчлэн сайжруулах, сэргээн засварлах ажлыг нэгтгэн зохион байгуулж, хэрэгжүүлэх, ашиглагч байгууллагуудын ажлыг уялдуулан зохицуулж батлагдсан тушаал, захирамж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод хяналт, аудит хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэт хотын захирагчийн алба 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 218,647.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,279.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,293.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эрдэнэт хотын захирагчийн алба 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31,195.8 мянган төгрөгөөр буюу 77.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Бараа материал	18,502.9	15,848.4	(2,654.5)
Үндсэн хөрөнгө	21,961.9	55,812.3	33,850.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>40,464.8</b>	<b>71,660.7</b>	<b>31,195.9</b>
Өр төлбөр	0.0	0.0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	40,464.8	71,660.7	31,195.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>40,464.8</b>	<b>71,660.7</b>	<b>31,195.9</b>

Бараа материалын данс 15,848.4 мянган төгрөг болж 2,654.5 мянган төгрөгөөр буурсан нь оны эцэст бараа материалаас үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 55,812.3 мянган төгрөг болж 33,850.4 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө шилжүүлэн авснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 71,660.7 мянган төгрөг болж 31,195.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Эрдэнэт хотын захирагчийн албаны санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 2,451.4 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар өсөж, нийт зардал өмнөх оноос 33,697.6 мянган төгрөгөөр буюу 14.4 хувиар буурсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Эрдэнэт хотын захирагчийн алба нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 297,439.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 297,439.0 сая төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 78,791.9 мянган төгрөгөөр бууруулан 218,647.1 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого арга хэмжээг хэрэгжүүлэхээр 218,647.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд 217,406.6 мянган төгрөгийг зарцуулж, 1,240.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 217,406.6 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 41.2 мянган төгрөг, томилолтын зардлыг 560.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 570.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын захирамжаар 1,733.8 мянган төгрөгийн барилга экспо-д оролцох санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Үүнээс 1,733.8 мянган төгрөгийг 11 албан хаагчийн томилолтын зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрдэнэт хотын захирагчийн алба нь 2021 онд нийт 266,347.3 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 266,347.3 мянган төгрөгийн 149 мэдээллийг ил тод байршуулсан байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 1,168.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 2,680.8 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт							
Албан шаардлага	1	1,168.3	1	1,168.3			
Зөвлөмж	1	2,680.8	1	2,680.8			
Нийт дүн	2	3,849.1	2	3,849.1			

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар анхаарал татахаар бусад чухал асуудал байхгүй байна.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7,391.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,580.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 5,811.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

##### 4.1 Залруулсан алдаа

Тайлант оны санхүүгийн тайланд залруулга хийх алдаа зөрчил үүсээгүй болно.

##### 4.3 Албан шаардлага

Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу төсөвт 10-аас доошгүй хувийн хэмнэлт үүсгэхээр тооцож зарцуулах байсан хэдий ч хэмнэлт үүсгээгүй, хөдөлмөр хамгааллын хувцас худалдан авсан тул 1 албан шаардлага хүргүүлэв.

##### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл, санхүүгийн байдлын тайлангийн бараа материалын дансны үлдэгдэл санхүүгийн программд зөрүүтэй бүртгэгдсэн байх ба 2018 онд санхүүгийн программын өөрчлөлтөөс шалтгаалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 18.2-т “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Бараа материалын бодит үлдэгдэл болон санхүүгийн программын үлдэгдлийг тулгаж, баталгаажуулан, 2022 оны эхний хагас жилийн тайланд залруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Эрдэнэт хотын захирагчийн алба	2	7,391.7					1	1,580.0	1	5,811.7